

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/004/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com</p>
---------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 24 № 89

танай _____ -ны № _____ -т

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.АРИУНБУЯН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод нутгийн уулзалт арга хэмжээнд 8,520.0 мянган төгрөгийг, ахмад настан, хүүхдийн баяр, хичээлийн шинэ жилийн нээлтийн тэмцээний шагнал, урамшуулал, дэмжлэгт 22,689.2 мянган төгрөгийг зарцуулсан;

8225020226

- Он дамжсан өглөгийг барагдуулаагүйгээс гэрээгээр гүйцэтгэх ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгээгүй,
- Төсвөөс албан хаагч нарт 1,050.0 мянган төгрөгийн бэлэг дурсгал зүйл болон хоолны мөнгө 1,095.0 мянган төгрөгөөр илүү олгосон,
- Сумын 100 жилийн ойн дэмжлэгт төсвөөс олгосон 100,000.0 мянган төгрөгөөр баярын хүлээн авалт, бэлэг дурсгалын зүйл, айраг, хүнсний материал худалдан авч хоол бэлтгэх арга хэмжээнд 98,398.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын 100 жилийн ой тохиож аймгийн төсвөөс 100,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноос 98,398.4 мянган төгрөгөөр баярын хүлээн авалт, бэлэг дурсгалын зүйл, айраг, хүнсний материал худалдан авч хоол бэлтгэхэд зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 5 зорилт, 100 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийн тайланг хүргүүлснээс 70 арга хэмжээг бүрэн, 21 арга хэмжээг 70 хувь, 3 арга хэмжээ 50 хувь, 5 арга хэмжээ 30 хувьтай, сумын Засаг даргаас нийт дүнгээр 84.4 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	406,814,953.19	449,515,618.19
33	АВЛАГА	59,954,283.00	47,488,948.00
335	Бусад авлага	59,954,283.00	47,488,948.00
3351	Байгууллагаас авах авлага	40,000,000.00	46,500,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	19,954,283.00	988,948.00
35	БАРАА МАТЕРИАЛ	346,860,670.19	402,026,670.19
351	Түүхий эд материал	37,000,002.00	37,000,002.00
35110	Тусгай зориулалттай материал	37,000,002.00	37,000,002.00
354	Хангамжийн материал	85,184,108.19	140,350,108.19
35410	Бичиг хэргийн материал	667,000.00	667,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,970,000.00	10,440,000.00
35470	Бусад хангамжийн материал	81,547,108.19	129,243,108.19
35600	Мал амьтад	224,676,560.00	224,676,560.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,981,720,030.81	2,306,797,044.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,981,720,030.81	2,306,797,044.61
392	Биет хөрөнгө	1,881,958,030.81	2,207,035,044.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,812,395,758.00	2,095,953,124.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(371,439,899.51)	(431,107,550.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	485,231,000.00	396,295,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(289,546,919.65)	(294,534,322.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	201,612,442.00	212,657,080.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(108,387,771.13)	(77,604,301.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	140,979,263.00	288,970,453.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,068,521.05)	(57,631,667.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	23,032,000.00	23,032,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,107,020.85)	(3,763,870.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,257,700.00	54,769,100.00
393	Биет бус хөрөнгө	99,762,000.00	99,762,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	99,762,000.00	99,762,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,388,534,984.00	2,756,312,662.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,388,534,984.00	2,756,312,662.80
51	Засгийн газрын хувь оролцоо	2,388,534,984.00	2,756,312,662.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,189,424.37	296,189,424.37
51101	Өмч: - төрийн	296,189,424.37	296,189,424.37
512	Хуримтлагдсан үр дүн	2,090,238,442.73	2,458,016,121.53
51210	Өмнөх үеийн үр дүн	2090238442,73	2,090,238,442.73
51220	Тайлант үеийн үр дүн		367,777,678.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,107,116.90	2,107,116.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,388,534,984.00	2,756,312,662.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,005,377,859.00	1,711,282,148.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	312,447,841.00	528,519,659.00
120	Нийтлэг татварын бус орлого	312,447,841.00	528,519,659.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	312,447,841.00	522,254,659.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	297,790,626.00	499,662,159.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,657,215.00	22,592,500.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	-	6,265,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	692,930,018.00	1,180,837,489.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,763,918.00	129,375,589.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,172,918.00	127,289,589.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	591,000.00	2,086,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	616,166,100.00	1,053,386,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	616,166,100.00	1,053,386,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	805,114,590.86	1,298,273,385.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	805,114,590.86	1,298,273,385.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	744,006,962.07	1,111,248,734.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,559,866.18	579,754,066.00
210101	Үндсэн цалин	196,840,721.71	272,531,497.00
210102	Нэмэгдэл	103,718,525.47	205,904,073.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,341,000.00	11,373,000.00
210104	Урамшуулал	27,585,789.00	29,289,120.00
210105	Гэрээт ажлын хөлс	45,073,830.00	60,656,376.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,662,169.47	68,856,890.52
210201	Тэтгэврийн даатгал	36,730,969.47	47,601,790.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,732,800.00	5,313,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,186,200.00	2,656,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,600.00	2,656,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,465,600.00	10,627,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,149,074.56	29,438,285.32
210301	Гэрэл, цахилгаан	2,472,274.56	14,284,285.32
210302	Түлш, халаалт	8,624,000.00	15,154,000.00
210303	Цэвэр, бохир ус	52,800.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	60,839,765.00	56,895,364.51
210401	Бичиг хэрэг	2,976,270.00	2,796,850.00
210402	Тээвэр, шатахуун	47,745,795.00	48,917,059.00
210403	Шуудан, хэлбөө, интернэтийн төлбөр	1,194,160.00	1,506,955.51
210404	Ном, хэвлэл	9,240.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	580,000.00

Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан


210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,472,300.00	1,624,500.00
210408	Бараа материал акталсны зардал	7,442,000.00	1,470,000.00
2105	Нормативт зардал	510,000.00	1,595,000.00
210502	Хоол, хүнс	510,000.00	510,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,085,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,689,500.00	19,652,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	120,000.00	-
210604	Урсгал засвар	11,569,500.00	19,652,200.00
2107	Томилолт, зочны зардал	21,276,000.00	20,670,000.00
210702	Дотоод албан томилолт	21,276,000.00	20,670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,061,707.00	52,488,366.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,007,846.00	50,565,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,403.00	573,904.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	546,350.00	550,000.00
210807	Газрын төлбөр	31,758.00	20,362.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,258,879.86	281,898,561.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,053,000.00	106,122,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	140,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,205,879.86	175,635,461.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,110,628.79	187,024,651.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,327,240.00	68,094,273.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,557,020.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,327,240.00	35,142,214.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	12,395,039.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	34,780,388.79	118,930,378.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,401,148.79	117,328,739.65
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг-нэмэлт	379240.00	1601639.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	389,211,759.00	657,895,248.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	200,263,268.14	413,008,762.10
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,307,405.41	45,231,083.30
230001	Эргэж төлөгдөх зээл	8,307,405.41	45,231,083.30
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,307,405.41)	(45,231,083.30)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	191,955,862.73	367,777,678.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	692,930,018.00	1,189,027,489.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	6265000,00
120	Нийтлэг татварын бус орлого	-	6265000,00

ГАА-2025/004/НА-СТА-ТШЗ



Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120009	Бусад орлого		6265000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
		692,930,018.00	1,180,837,489.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,763,918.00	129375589,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,172,918.00	127,289,589.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	591,000.00	2086000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	616,166,100.00	1,053,386,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	616,166,100.00	1,053,386,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	655,134,496.00	1,142,746,089.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	655,134,496.00	1,142,746,089.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	594,026,867.21	966,002,576.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,407,866.18	570,597,901.00
210101	Үндсэн цалин	196,838,220.18	263,375,332.00
210102	Нэмэгдэл	102,569,027.00	205,904,073.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,341,000.00	11,373,000.00
210104	Урамшуулал	27,585,789.00	29,289,120.00
210105	Гэрээт ажлын хөлс	45,073,830.00	60,656,376.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,662,169.47	69,328,859.52
210201	Тэтгэврийн даатгал	36,730,969.47	48,073,759.52
210202	Тэтгэмжийн даатгал	2,732,800.00	5,313,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,186,200.00	2,656,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	546,600.00	2,656,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,465,600.00	10,627,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,797,074.56	36,908,285.32
210301	Гэрэл, цахилгаан	2,472,274.56	14,284,285.32
210302	Түлш, халаалт	8,272,000.00	22,624,000.00
210303	Цэвэр, бохир ус	52,800.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	52,238,250.00	56,759,364.51
210401	Бичиг хэрэг	2,792,270.00	2,796,850.00
210402	Тээвэр, шатахуун	46,342,580.00	48,917,059.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,194,160.00	1,506,955.51
210404	Ном, хэвлэл	9,240.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	580,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,900,000.00	2,958,500.00
2105	Нормативт зардал	510,000.00	1,595,000.00
210502	Хоол, хүнс	510,000.00	510,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,085,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,832,500.00	20,933,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	143,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	120,000.00	-
210604	Урсгал засвар	11,569,500.00	20,933,700.00
2107	Томилолт, зочны зардал	21,276,000.00	20,670,000.00
210702	Дотоод албан томилолт	21,276,000.00	20,670,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,061,707.00	52,113,666.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,007,846.00	50,190,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,403.00	573,904.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	546,350.00	550,000.00

**Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	31,758.00	20,362.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,241,300.00	137,095,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,241,300.00	136,955,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	140,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,107,628.79	176,743,512.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,327,240.00	57,813,134.00
213204	Ажил олгогчдоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,557,020.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,327,240.00	35,142,214.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	2,113,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	34780388,79	118930378,65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,401,148.79	117,328,739.65
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	379,240.00	1,601,639.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	37,795,522.00	46,281,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	37,795,522.00	46,281,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,795,522.00	46,281,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	37,795,522.00	46,281,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	37,795,522.00	46,281,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(37,795,522.00)	(46,281,400.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,189,424.37	2,107,116.90	1,898,282,580.00	2,196,579,121.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,189,424.37	2,107,116.90	1,898,282,580.00	2,196,579,121.27
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	191,955,862.73	191,955,862.73
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,189,424.37	2,107,116.90	2,090,238,442.73	2,388,534,984.00
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	296,189,424.37	2,107,116.90	2,090,238,442.73	2,388,534,984.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,189,424.37	2,107,116.90	2,090,238,442.73	2,388,534,984.00
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	367,777,678.80	367,777,678.80
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	296,189,424.37	2,107,116.90	2,458,016,121.53	2,756,312,662.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,053,386,900.00	942,323,160.35	111,063,739.65	89.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,053,386,900.00	942,323,160.35	111,063,739.65	89.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	983,887,300.00	884,510,026.35	99,377,273.65	89.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,375,000.00	570,597,901.00	50,777,099.00	91.83
210101	Үндсэн цалин	265,566,000.00	263,375,332.00	2,190,668.00	99.18
210102	Нэмэгдэл	234,133,000.00	205,904,073.00	28,228,927.00	87.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,638,000.00	11,373,000.00	11,265,000.00	50.24
210104	Урамшуулал	47,801,000.00	29,289,120.00	18,511,880.00	61.27
210105	Гэрээт ажлын хөлс	51,237,000.00	60,656,376.00	(9,419,376.00)	118.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,734,300.00	69,328,859.52	10,405,440.48	86.95
210201	Тэтгэврийн даатгал	58,479,200.00	48,073,759.52	10,405,440.48	82.21
210202	Тэтгэмжийн даатгал	5,313,800.00	5,313,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,656,900.00	2,656,900.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,656,900.00	2,656,900.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,627,500.00	10,627,500.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,800,000.00	24,908,285.32	2,891,714.68	89.60
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,284,285.32	715,714.68	76.14
210302	Түлш, халаалт	24,300,000.00	22,624,000.00	1,676,000.00	93.10
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	-	500,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,900,000.00	53,758,414.51	5,141,585.49	91.27
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,796,850.00	3,150.00	99.89
210402	Тээвэр, шатахуун	47,500,000.00	45,916,109.00	1,583,891.00	96.67
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	4,350,000.00	1,506,955.51	2,843,044.49	34.64
210404	Ном, хэвлэл	500,000.00	-	500,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	750,000.00	580,000.00	170,000.00	77.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,958,500.00	41,500.00	98.62
2105	Нормативт зардал	3,030,000.00	1,595,000.00	1,435,000.00	52.64
210502	Хоол, хүнс	510,000.00	510,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,520,000.00	1,085,000.00	1,435,000.00	43.06
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,880,000.00	39,463,400.00	17,416,600.00	69.38
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,880,000.00	14,379,700.00	5,500,300.00	72.33
210602	Тавилга	5,000,000.00	4,150,000.00	850,000.00	83.00
210604	Урсгал засвар	32,000,000.00	20,933,700.00	11,066,300.00	65.42
2107	Томилолт, зочны зардал	21,000,000.00	20,670,000.00	330,000.00	98.43
210702	Дотоод албан томилолт	21,000,000.00	20,670,000.00	330,000.00	98.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,373,000.00	1,923,366.00	1,449,634.00	57.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,000.00	-	480,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	604,800.00	403,200.00	60.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	64,300.00	135,700.00	32.15
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825,000.00	573,904.00	251,096.00	69.56
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	110,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	550,000.00	170,000.00	76.39
210807	Газрын төлбөр	30,000.00	20,362.00	9,638.00	67.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,795,000.00	102,264,800.00	9,530,200.00	91.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,795,000.00	102,124,300.00	7,670,700.00	93.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	140,500.00	1,859,500.00	7.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,499,600.00	57,813,134.00	11,686,466.00	83.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,499,600.00	57,813,134.00	11,686,466.00	83.18
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,322,000.00	20,557,020.00	9,764,980.00	67.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,477,600.00	35,142,214.00	335,386.00	99.05
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,700,000.00	2,113,900.00	1,586,100.00	57.13
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,053,386,900.00	942,323,160.35	111,063,739.65	89.46
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,053,386,900.00	936,058,160.35	117,328,739.65	88.86

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 8,119.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 2 алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа: Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 6,500.0 мянган төгрөгийг Агнуур судлалын нийгэмлэгт "Агнуурын менежментийн төлөвлөгөөг шинэчлэх ажлыг гүйцэтгэх"-гэрээний дагуу төлбөрийг төлсөн,
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчин санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 1,619.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж НДШ-ийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 173,677.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 173,677.6 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 2,145.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 146,918.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага, 24,614.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

Төлбөрийн акт

1. ЗДТГ-ын албан хаагчдад 1 дүгээр сарын хоолны мөнгийг 495.0 мянган төгрөгийг илүү, томилолтоор ажилласан ажиллагсад хоолны мөнгийг давхардуулан 600.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Говь-Алтай аймгийн Алтай сумын ЗДТГ-ын даргын 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/05 тушаалд заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас шинэ жилийн баярыг тохиолдуулан албан хаагчдад 1,050.0 мянган төгрөгийг бэлэг худалдан авч хүндэтгэл үзүүлэн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

1. Санхүүгийн тайлангийн авлагын дансанд бүртгэлтэй өмнөх онуудад үүссэн Бүрдмэл-Алтай ХХК-д гэрээний дагуу урьдчилан төлсөн авлагын 40,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, гэрээний дагуу ажлыг бүрэн гүйцэтгүүлэн хүлээн аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн ер төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж ер төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэсэн заалттай нийцэхгүй нийцэхгүй иж бүрэн, үнэн зөв, бодитой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд заасны дагуу ажлаа гүйцэтгээгүй, хүлээлгэн өгөөгүй байхад шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй, алданги тооцоогүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Сумын 100 жилийн ойн дэмжлэгт олгосон санхүүжилтийг 5 багц болгон цахим тендерийг зохион байгуулж иргэнээс айраг худалдан авахад 20,000.0 мянган төгрөг, Улаанбаатар бусад хотоос ирсэн иргэдийн гарын бэлэг арга хэмжээнд 20,000.0 мянган төгрөг, Алтай сумын уугуул иргэнд гарын бэлэг нийлүүлэх арга хэмжээнд 20,000.0 мянган төгрөг, хүлээн авах, баяр наадмын зохион байгуулалттай холбоотой бусад зардалд 14,075.0 мянган төгрөг, ирсэн зочдын байранд хоол хийх материал худалдан авахад 15,491.9 мянган төгрөг, ойн номын эх бэлтгэх зардалд 6,000.0 мянган төгрөг, наадмын нээлт, бусад арга хэмжээнд 2,831.4 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах," 15.1.7-т "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэсэн заалттай нийцэхгүй иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Засаг даргын нөөц хөрөнгөөс Улаанбаатар, Дархан, Эрдэнэт нутгийн уулзалт арга хэмжээнд 5,780.0 мянган төгрөг, шагнал, урамшуулал, дэмжлэгт 2,740.0 мянган төгрөгийг зарцуулж, үр дүнгүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар

зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй иж бүрэн, бодитой, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг нутгийн зөвлөлийн уулзалт, шагнал урамшуулалд зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмдэглэлт баяр, ахмад настан, хүүхдийн баяр, хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээг тохиолдуулан уралдаан, тэмцээн арга хэмжээ зохион байгуулахад төсвөөс 22,689.2 мянган төгрөгийг шагнал, урамшуулал, дэмжлэгт зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй иж бүрэн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар тэмдэглэлт баяр, арга хэмжээ, тэмцээн уралдаанд зарцуулдаг байдлыг таслан зогсоож, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж байх.

Илрүүлэлт:

2. Нэмэлт санхүүжилтийн данснаас иргэнд барааны үнийг 1,925.0 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, буцааж дансанд тушаасан орлогыг өөрийн орлогоор бүртгэж тайлагнан төрийн санд буцаан төвлөрүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох

Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцэхгүй иж бүрэн, үнэн зөв, бодитой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд харилцах дансанд орсон гүйлгээний залруулга, илүү төлсөн болон буцаасан зардлын дүнг тусгахгүй дансны бичилтийг зөв бүртгэн, орлогыг үнэн зөв хүлээн зөвшөөрч зарцуулалтыг гаргаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлэе

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын ЗДТГ	2	8,119.5	-	-	2	8,119.5	2	8,119.5				
Дүн	2	8,119.5	-	-	2	8,119.5	2	8,119.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтай сумын ЗДТГ	7	173,677.6	2	2,145.0	3	146,918.4	2	24,614.2	-	-	-	-
Дүн	7	173,677.6	2	2,145.0	3	146,918.4	2	24,614.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алтай сумын ЗДТГ	-							
Дүн	-							
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алтай сумын ЗДТГ	-							
Дүн	-							
-Нийт дүн	-							

Говь-Алтай аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

-----oOo-----